



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2018 он 03 дугаар
сарын 05 ны өдөр

Дугаар ХЭГ/434


Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.БАТБОЛД ТАНАА

Асуулгын хариу хүргэх тухай

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид бүртгүүлэн нээлттэй худалдах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хувьцаа эзэмшигч иргэн, аж ахуйн нэгжүүдэд ногдол ашгийг хуваарилах боломжийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулгын хариуг үүгээр Танд хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.БАТБОЛДООС ЕРӨНХИЙ САЙД
У.ХҮРЭЛСҮХЭД ХАНДАЖ ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ**

Асуулт 1. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид бүртгүүлэн нээлттэй арилжих Засгийн газрын тогтоолыг энэ онд багтаан хэрэгжүүлэх төлөвлөгөө, бэлтгэл ажлын талаар.

Хариулт.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны 20 хүртэлх хувийг Монгол Улсын иргэдэд эзэмшүүлэх, 10 хүртэлх хувийг үндэсний аж ахуй нэгжид худалдах, 20 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн зах зээлд гаргахаар шийдвэрлэсний дагуу уг тогтоолд заасан арга хэмжээг холбогдох талууд зохион байгуулж ирсэн.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг хөрөнгийн зах зээлд гаргах бэлтгэл ажлыг хангах зорилгоор холбогдох яам, газрын төлөөллийг оролцуулан томилсон Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн “Эрдэнэс Монгол” ХХК болон түүний охин компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 154 дүгээр тогтоолыг баталсан бөгөөд одоо “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны бүртгэлийг цэгцлэх ажил дуусах шатандаа явж байна.

Засгийн газрын 2017 оны 154 дүгээр тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигчийн бүртгэлийг үндэслэн хувьцааны нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр тооцож, нийт гаргасан хувьцааг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн санхүүгийн тайланд тусгахыг даалгасан. Үүний дагуу “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, “Эрдэнэс Тавантолгой” ХК зэрэг холбогдох байгууллагуудын төлөөллийг хамруулсан Ажлын хэсэг байгуулан ажиллаж, санал, дүгнэлт гаргасан.

Ажлын хэсгийн саналын дагуу Сангийн яам, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлтэй Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн бүртгэл дэх хувьцаа эзэмшигчдийн мэдээлэлтэй тулгалт хийж “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны эзэмшлийн бүтцийг дараах байдлаар бүртгэсэн болно.

	Хувьцаа эзэмшигчид		Хувьцааны тоо	Хувь
1	“Эрдэнэс Монгол” ХХК		9,780,711,099	65.2%
2	ААН	486	7,065,038	0.05%
3	Иргэд	2,511,332 иргэн	2,212,223,863	14.75%
4	Зарласан хувьцаа		3,000,000,000	20%
			12,000,000,000	100%

Мөн Засгийн газрын 2017 оны 154 дүгээр тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийт 15 тэрбум ширхэг хувьцааны 80 хувь буюу 12 тэрбум ширхэг хувьцааг гаргасан хувьцаагаар, 20 хувь буюу 3 тэрбум ширхэг хувьцааг зарласан хувьцаагаар компанийн дүрэмд тусгаж бүртгэхийг даалгасан. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн хуралдаанаар нийт гаргасан хувьцаагаа санхүүгийн тайландаа тусган компанийн дүрэмд хувьцаатай холбоотой өөрчлөлтийг тусгахаар шийдвэрлэсэн байна. Ойрын үед “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн дүрмийн өөрчлөлтийн асуудлыг тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлүүлэхээр хүлээгдэж байна.

Түүнчлэн, Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар “Эрдэнэс Монгол” ХХК болон түүний охин компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2017 оны 154 дүгээр тогтоолын биелэлтийн явцтай танилцаад тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээрх үүрэг даалгаврыг холбогдох албан тушаалтнуудад өгсөн болно.

Тухайлбал, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэх, хадгалах, өмчлөх, эрх шилжүүлэх үйл ажиллагааны журам”-ын дагуу “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн зарласан болон гаргасан хувьцааг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК дахь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгүүлж хадгалах, Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгжүүдийн эзэмшиж байгаа хувьцааны бүртгэлийг баталгаажуулах, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн сангаас Монгол Улсын иргэдийн мэдээллийг 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон 2018 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн дотор “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д хүргүүлж, өөрчлөлт орсон мэдээллийн дагуу компанийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд холбогдох өөрчлөлт оруулж байхыг холбогдох албан тушаалтнуудад үүрэг болголоо.

“Эрдэнэс Тавантолгой” ХК 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хувьцааг тусгаж бүртгэснээр нээлттэй хувьцаат компани болох бэлтгэл ажил хангагдах төлөвлөгөөтэй байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Монгол Улсын иргэн бүрт эзэмшүүлсэн хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа буюу дотоодын хөрөнгийн биржийн арилжааг эхлүүлэх бэлтгэл ажлууд дараах байдлаар хийгдэж байна.

Хөрөнгийн зах зээл дээр хувьцаа гаргах шат дараалал

Суурь бэлтгэл ажил /хоёрдогч, нэмэлт хувьцаа/-ын хүрээнд:

- 1.Төрийн эзэмшлийн хувь хэмжээг тодорхойлох;
- 2.Иргэд, аж ахуйн нэгжийн хувьцааны бүртгэлийг эцэслэн, баталгаажуулах;
- 3.Үнэлгээний, санхүүгийн болон зөвлөх компани сонгон шалгаруулж, гэрээ байгуулах;
- 4.Ордын нөөцийн үнэлгээ хийлгэх, шаардлагатай мэдээллийг үнэлгээний компанид гарган өгөх, хамтран ажиллах;

5. Бизнесийн үнэлгээ хийлгэх;
6. Ордын техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах;
7. Хувьцааг санхүүгийн тайланд бүртгэж, олон улсын санхүүгийн тайлагналын стандартад нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэх;
8. Компанийн бизнес төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах;
9. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулж, улсын бүртгэлийн газарт бүртгүүлэх;
10. "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-тай Үнэт цаасны хадгаламжийн гэрээ байгуулах;

11. Компанийн засаглал сайжруулах, мэдээллийн ил тод байдлыг хангах;

Хоёрдогч зэх зээлийн арилжааг нээх бэлтгэл ажлын хүрээнд:

1. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийг "Нээлттэй компани" болгож, хоёрдогч зах зээлийн арилжааг нээх бэлтгэл ажлыг эхлүүлэх талаар Засгийн газрын тогтоол гаргах;
2. Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж болон бусад холбогдох журмын дагуу үнэт цаасны бүртгэлийн шалгуурт бэлтгэх;
3. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлийг хуралдуулж холбогдох шийдвэр гаргуулах;
4. Андеррайтер, аудит, хуулийн зөвлөх компани сонгон шалгаруулж, гэрээ байгуулах;
5. Зөвлөх компаниудаар шаардлагатай судалгаа, шинжилгээ хийлгүүлэх;
6. Аудит, андеррайтэрийн дүгнэлт гаргуулах;
7. Үнэт цаасны танилцуулга боловсруулах;
8. Санхүүгийн зохицуулах хороонд хувьцаа бүртгүүлэх, хувьцаа арилжаалах, зөвшөөрөл авах;
9. "Монголын хөрөнгийн бирж" ХК-д хувьцаа бүртгүүлэх;
10. Хувьцаа танилцуулах аянг зохион байгуулах;
11. Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх;

Нэмэлт хувьцааг гадны хөрөнгийн зах зээлд гаргах бэлтгэл ажлын хүрээнд:

1. Хувьцааны 20 хүртэлх хөрөнгө оруулалт татах асуудлаар "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын холбогдох шийдвэрийг гаргуулах;
2. Хөрөнгө оруулалт татаж байгаа төслийн судалгаа, үр ашгийн тооцоолол, татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт, төлөвлөгөө боловсруулах;

3. Андеррайтер, аудит, хуулийн зөвлөх компани сонгон шалгаруулж, гэрээ байгуулах;

4. Зөвлөх компаниудаар шаардлагатай судалгаа, шинжилгээ хийлгүүлэх;

5. Аудит, андеррайтэрийн дүгнэлт гаргуулах;

6. Үнэт цаасны танилцуулга боловсруулах;

7. Гадны зохицуулах байгууллага, хөрөнгийн биржид давхар бүртгэл хийлгэх;

8. Хувьцаа танилцуулах аян зохион байгуулах;

9. Нэгж хувьцааны үнэлгээг тодорхойлох;

10. Нэмэлт хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх.

Гадаадын хөрөнгийн зах зээл дээр хувьцааны 20 хүртэлх хувийг гаргах зорилгоор 2017 оноос ордын нөөцийн үнэлгээний ажлыг эхлүүлсэн бөгөөд бусад бэлтгэл ажлуудыг энэ онд багтааж хангахаар төлөвлөн ажиллаж байна. /“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг хөрөнгийн зах зээлд гаргах төлөвлөгөөг хавсралт Хүснэгтээс харна уу./

Асуулт 2. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигч иргэд, аж ахуйн нэгжүүдэд хуваарилах бололцооны талаар.

Хариулт.

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь 2017 онд 1,18.4 тэрбум төгрөгийн экспортын орлоготой байснаас 438.4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Монгол Улсад 243.3 тэрбум төгрөгийн татвар төлж, Хөгжлийн банкны өр төлбөрийн үлдэгдэл 242.7 тэрбум, хүүний өглөг ₮94.1 тэрбум байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь 2016 оныг дуустал буюу сүүлийн 4 жил дараалан алдагдалтай ажиллаж байсан бол 2017 онд 438 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, өмнөх жилүүдийн хуримтлагдсан алдагдлыг бүрэн хааж, хуримтлагдсан ашгийн хэмжээг 22 тэрбум төгрөгт хүргэсэн.

Хөгжлийн банкны өр төлбөр 336,8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ээлжит Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах, эсэхийг хэлэлцэн шийдвэрлэхээр төлөвлөж байна.

---oOo---

